



ДОТООД ХУДАЛДАА

Монгол улсын бөөний болон жижиглэн худалдааны нийт борлуулалт 2014 онд 15616.1 тэрбум төгрөг байсан ба үүнээс 13470.3 тэрбум буюу 86.3 хувь нь нийслэл хотод дангаараа хийгдэж байна. Худалдааны нийт борлуулалтын 54.9 хувийг бөөний худалдаа, 45.1 хувийг жижиглэн худалдаа тус тус эзэлж байна.


Зураг 1. Худалдааны нийт борлуулалт, тэрбум төгрөг



2014 онд Улаанбаатар хотод 4173 хүнсний дэлгүүр, 45 бөөний худалдааны төв, 22 зах, 464 түргэн үйлчилгээний цэгүүд жилийн турш үйл ажиллагаа явуулсан байна.

Эдгээр худалдааны цэгт бөөний болон жижиглэнгийн нийт 13470.3 тэрбум төгрөгийн худалдаа хийгдсэн нь 2011 оноос 4931.8 тэрбум буюу 57.8 хувиар, 2012 оноос 1511.7 тэрбум буюу 12.6 хувиар, 2013 оноос 1295.5 тэрбум буюу 10.6 хувиар тус тус өссөн байна.


Зураг 2. Худалдааны нэг цэгт ногдох үйлчлүүлэгчийн тоо, аймаг, нийслэлээр



Хүснэгт 1. Бөөний болон жижиглэн худалдаа, 2012-2014 он, тэрбум төгрөг

	2012 он		Эзлэх %	2013 он		Эзлэх %	2014 он		Эзлэх %
	УБ	Улс		УБ	Улс		УБ	Улс	
Бөөний	7037.4	7668.5	91.8	6895.4	7078.6	97.4	7392.6	7625.3	96.9
Жижиглэн	4921.2	5681.5	86.6	5279.4	7377.8	71.6	6077.7	7990.8	76.1
Бүгд	11958.6	13350.0	89.6	12174.8	14456.4	84.2	13470.3	15616.1	86.3


Зураг 3. Худалдааны нийт борлуулалт, тэрбум төг



2014 онд Монгол улсын хэмжээнд худалдааны нийт борлуулалт 15616.1 тэрбум төгрөгт хүрчээ. Нийт борлуулалтын 86.3 хувь нь Улаанбаатар хотод, үлдсэн 13.7 хувь нь бусад аймгуудад хийгдсэн байна. Худалдааны салбарын нийт аж ахуйн нэгжийн 10.0 гаруй хувийнх нь жилийн борлуулалтын орлого 50 сая төгрөгөөс дээш ба

нийт борлуулалтын орлого 90.0 гаруй хувийг эзэлдэг байна.

Зураг 4. Худалдааны цэг, төрлөөр



Нийслэлийн худалдааны нийт цэгийн 88.7 хувь нь хүнсний дэлгүүр, 9.9 хувь нь түргэн үйлчилгээний цэг, 1.0 хувь нь бөөний худалдааны төв, үлдсэн 0.4 хувийг хүнсний болон барааны зах эзэлж байна.